



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар A/80

Пионер толгой

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээт  
дуудлага худалдаа зохион байгуулах  
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын “Газрын тухай” хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Гурванбулаг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2022 оны “ Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө батлах тухай” 10/13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээт дуудлага худалдааг хавсралтад дурдсан байршлуудад зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Отгончимэг -Гурванбулаг сумын Газрын даамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Р.Гантулга – Засаг даргын тамгын газрын дарга

Ш.Наранхүү - Байгаль орчны улсын байцаагч

2. Дахин дуудлага худалдааг 2023 оны 08 дугаар сарын 7-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж дуудлага худалдаа явуулсан үр дүнг дуудлага худалдаа явуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан Засаг даргын зөвлөлд танилцуулахыг дуудлага худалдааны комисст даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч /Э.Сүглэгмаа /-д үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



642201379